ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн барилгын дотор засал, хаалга, шал, дотор гэрэлтүүлгийн засварын ажил /Тус барилга нь тэнхлэгээрээ 39.0х16.6м хэмжээтэй өрөг бүтээцтэй, шувуу нуруу дээвэртэй 1 давхар барилга болно/:

А. Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНбД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсрууж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Г. Үнийн саналд зураг төслийн үнийг **8 144 223** төгрөгөөр тусгаж ирүүлэх ба Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12*(2020)-г мөрдлөг болгоно.

Д. Барилга байгууламжийн ажлын төсвийг тооцохдоо "Барилгын төсөв зохиох дүрэм" БНбД 81-95-12*(2020)-д заасны дагуу тоног төхөөрөмжийн үнийг материалын үнэд оруулахгүйгээр тусд нь тооцож ирүүлнэ.

Е. Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. Буулгалтын ажил

Эрүүл мэндийн төвийн барилгын гадна, дотор хана, таазны хөндийрсөн шаврыг ховхолж унагаан, гадаргууг бүрэн хусаж буулгах, дотор хаалганы хүрээ хайрцгийг бүрэн задалж буулган, шавардлагыг ховхолж унагаах шаардлагатай. Мөн зураг төсөлд заасны дагуу хэвтэн эмчлүүлэх тасаг /25, 26/ номерийн өрөөнүүдийн дундах хамар ханыг буулгах, хэвтэн эмчлүүлэх тасаг, өдрийн эмчилгээний өрөө /24, 25/, хэвтэн эмчлүүлэх тасаг, хүлээн авах хэсэг /26, 27/-ийн хоорондын хамар ханын хэсэгт хаалга гаргах зориулалтаар буулгах, ажлууд хийгдэнэ. Буулгалтын ажил гүйцэтгэх үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж ажиллана. Барилгаас гарсан хог хаягдлыг ялган ангилсаны дараа бүрэн цэвэрлэж орчмын газрыг хэвийн байдалд оруулж өгнө.

2. Цонх, хаалганы ажил

- Цонх, хаалганы амалгаанд шаврын засварын ажил, цонхонд сайн чанарын PVC хуванцар тавиур суулгах шаардлагатай.

- Хүлээн авах хэсэг, тусгаарлах өрөө /14, 26/-үүдэд дулаан тусгаарлагчтай металл рамтай хатжуулсан шилэн хаалга, төрөх тасаг /№4/ өрөөнд давхар шилэн багцтай хуванцар рамтай 2 самбартай хаалга, коридор, тусгаарлах өрөө, яаралтай тусламжийн өрөөнүүдэд металл рамтай хатжуулсан шилэн хана суурилуулна.

- Гадна болон дотор хаалгыг эрх бүхий байгууллагаар хийлгэж угсруулах эсвэл импортын материал худалдан авах тохиолдолд чанартай бат бөхийг сонгон хэрэглэх шаардлагатай. Хаалгыг захиалахдаа буулгалтын ажлын явц дуусаны дараа газар дээрээс бодит хэмжээг дахин авах шаардлагатай. Хаалга, цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амалгаа хийнэ.

3. Дотор заслалын ажил

- Гадна дотор хуурай ба нойтон шавардлага, шиллэгээ, өнгөлгөөний ажилд БНбД 31-10-05-г мөрдөнө. Дотор засварын ажилд БНбД3.04.02.88-г мөрдөнө.

- Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

- Зураг төсөлд заагдсан /№26, 8, 24/ тоот өрөөнүүдийн өрөгт хамар ханыг буулгаж шаврын заслал хийнэ. №13 тоот өрөөний хаалгыг багасган өрж шавардлага заслалын ажлыг хийж гүйцэтгэнэ. Хананд замаскан тэгшилгээ хийж нямбайлан зүлгүүрдсэний дараа 1.8м-ийн өндөрт тосон будаг түүнээс дээш ханыг таазны хамт сайн чанарын эмульсээр 2 үе будна. №4, 9, 10 тоот өрөөнүүдэд 2.8м-ийн түвшинд өнгөлгөөний хавтанцар наана. №9, 10 тоот өрөөнүүдэд лампиран хавтангаар таазанд өнгөлгөө хийнэ мөн төрөх өрөөний таазанд тэгшилгээ хийж өнгийн тосон будгаар гар аргаар 2 үе сайн чанартай будна. Дотор цонх хаалганы амалгаанд тэгшилгээ хийж, тосон будгаар нямбайлан будна. №6, 25, 14 тоот өрөөнүүдэд металл рамтай, хаалгатай цул хатжуулсан шилтэй шилэн хана угсарч өгнө.

4. Шалны ажил

- Шалны ажилд БНбД 3.04.04-90, БНБД– 81-11-06 мөрдлөг болгоно.

- Одоо байгаа банзан шал, плитан шал, хулдаасан шал зэргийг задлан хуулж буулгана. Түрдэг тэргээр шороо зөөж шалан доор 30см зузаантай дэвсгэр хийж нягтруулна. БМ100 маркын бетоноор 10см зузаан шал цутгаж хийнэ. Шаланд 2см-ийн зузаан цементийн тэгшилгээг жигд нямбай хийж өнгөлсний дараа эмнэлгийн зориулалт бүхий 2мм-ээс багагүй зузаантай хулдаасыг зориулалтын гагнаасаар гагнаж наана. Хулдаасан шалны хөвөөг зориулалтын PVC хөвөөнд хулдаасыг өгсүүлэн хийх шаардлагатай. №4, 7, 8, 10, 16, 20, 21, 22, 26, 30, 31 тоот өрөөнүүдэд 1 үе хар цаасаар уур ус тусгаарлагч хийсний дараа цементэн зуурмаг дээр шалны плитан хавтанцар нааж өнгө дагуу хавтанцараар шалны хөвөөг хана дагуу жигд нааж өгнө.

5. Бусад ажил

- Эмнэлгийн барилга нь дулаан хангамжийн төвлөрсөн системд холбогдсон бөгөөд дулаан хангамжийн узель нь хуучин гар аргаар галладаг зуухны өрөөнд шинэчлэгдэн угсрагдсан. Тус өрөөний шалны түвшин нь нүүрс нөөцлөхөд зориулагдсан нам дор түвшинтэй байсныг шороогоор дүүргэж нягтруулан пелонк дэвсэж БМ100 маркын бетоноор 10см зузаан шал цутгаж түүн дээр 2см зузаан цементэн тэгшилгээ хийнэ.

- Халдвартын тасагруу орох гадна хаалганы үүдэнд тамбур шинээр хийнэ. Тамбур нь бетон шугаман суурь, блокон хана, цонх, хаалга, эрдэс хөвөн дулаалгатай модон хучилт зэргээс бүтэх ба уг хийцийдүүг зураг төслийн дагуу чанартай, нямбай хийж гүйцэтгэнэ. Тамбурын гадна фасадны өнгийг эмнэлгийн өнгө дагуу хийнэ. Тамбурын гадна довжоо, пандус зэргийг БМ150 маркын бетоноор цутгаж хийнэ. Пандусанд стандартад нийцсэн төмөр хашлага хийж өнгийн тосон будгаар 2 үе будна. Довжоо пандусны хажуу ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардаж суурь цавуун хөрсжүүлэлт хийсний дараа сайн чанарын гадна зориулалтын эмульсээр будна.

Барилгын засварын ажилд мөрдөж ажиллах БНбД, стандартууд

Гэрээт ажлыг гүйцэтгэхэд мөрдөж ажиллах Монгол улсын барилгын норм, дүрмүүд БНбД ба стандартууд:

	Норм, дүрмийн нэр	Дугаар
1-р хэсэг. Барилгын үйлдвэрлэл, ажил гүйцэтгэх ба хүлээн авах		
1.1	Барилгын үйлдвэрлэл, ажил гүйцэтгэх ба хүлээн авах үндсэн дүрэм	БНбД 3.01.01-88
1.2	Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт	БНбД 12-01-09
1.3	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх ашиглалтад оруулах дүрэм	ЗГ-ын 2021 оны 212, 213 дугаар тогтоол
1.4	Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх аюулгүй ажиллах арга техникийн нэгдсэн дүрэм	БНбД 3.01.05-90
1.5	Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм I Хэсэг. Ерөнхий шаардлага	БНбД 12-03-04
1.6	Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм II Хэсэг. Техникийн аюулгүй ажиллагаа.	БНбД 12-04-06
1.7	Барилгын талбайн даамлын үлгэрчилсэн дүрэм	УББ 12-204-01
1.8	Ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан зөвлөмж	БД 12-106-14
1.9	Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм	БД 12-105-07
1.10	Барилгын үйлдвэрлэлийн технологи зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар	БД 12-104-11
1.11	Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар	БД 12-101-05
1.12	Заслын ажил	БНбД 31-10-05
1.13	Байгууламж ба барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах	БНбД 20-02-11
1.14	Шалны ажил	БНбД 31-09-05

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилга байгууламжийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

7. Барилга байгууламжийн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
9. Хэрвээ талбайн тохижилт, шугам сүлжээний зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
12. Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 14.3–т */барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/* 14.4-т */14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/* 14.5-д */14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/* 14.6-д */14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/* гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага **чанарын баталгаа** гаргаж өгнө.